



*The AMERICAN CHAMBER of Commerce in Mongolia*

# ИНТЕРНЕТИЙН ҮР ДҮНТЭЙ ЗАСАГЛАЛЫН ТАЛААРХ БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ

2023 оны 10-р сар

## **Монгол дахь Америкийн Худалдааны Танхим**

### **Интернетийн үр дүнтэй засаглалын талаарх бодлогын баримт бичиг**

Монгол дахь Америкийн Худалдааны Танхим (АмЧам) Мэдээллийн технологи, цахим эдийн засгийн хороогоороо дамжуулан энэхүү бодлогын баримт бичгийг боловсруулсан. Бодлогын баримт бичгийг бүтнээр, эсвэл хэсэгчлэн дахин хэвлэхэд тус танхимаас зөвшөөрөл авна.

Монгол дахь Америкийн Худалдааны Танхим

Зохиогчийн эрх 2023 ©



## Хураангуй

Энэхүү бодлогын баримт бичгийн гол зорилго нь олон нийтийн сүлжээнд гарч буй гэмт хэрэгт дүн шинжилгээ хийх, интернетийн аюулгүй байдлыг хангах, хүний үндсэн эрх, түүний дотор үг хэлэх эрх чөлөөг хамгаалах үр дүнтэй стратегийг санал болгох явдал юм. Тус баримт бичигт дараах асуудлыг тусгасан. Үүнд:

а) Залилан, хүүхдэд садар, самууныг сурталчлах, уруу татах, худал мэдээлэл түгээх зэрэг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр тархсан цахим гэмт хэргийн мөн чанар, үр дагаврыг судлах.

б) Монгол Улсад мөрдөгдөж буй хууль тогтоомжууд, түүний дотор саяхан хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлсэн хуулийн төсөл, бодлогын талаар тоймлон хүргэх.

в) Олон нийтийн сүлжээнд тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэхийн тулд бусад улс оронд хэрэгжүүлж буй хууль тогтоомжийн давуу болон сул талыг судлах.

г) Цахим гэмт хэрэгтэй тэмцэх зорилгоор үг хэлэх болон үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг тэнцвэртэй хангахад тулгарч буй бэрхшээлийг судлах.

е) Олон нийтийн аюулгүй байдлыг хангах, хувь хүний эрх чөлөөг хамгаалах, олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд тулгарч буй асуудлыг зохицуулах чиглэлээр интернетийн үр дүнтэй засаглалын үндсэн зарчмуудыг санал болгох.



## Оршил

Олон нийтийн сүлжээ нь хүмүүсийн амьдралын салшгүй нэг хэсэг болж, харилцаа холбоо өргөжих, мэдээлэл солилцох зэрэг давуу талыг бий болгож байгаа хэдий ч цахим гэмт хэрэгтэй холбоотой саар асуудал дэлгэрч байна. Монгол Улс бусад орны нэгэн адил залилан мэхлэх, хүүхдэд садар, самууныг сурталчлах, уруу татах, худал мэдээлэл тараах зэрэг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр гарч буй цахим гэмт хэрэгтэй холбоотой асуудлыг зохицуулах, хуульчлах зайлшгүй шаардлага тулгарч байна. Ингэхдээ Монгол Улсын хууль тогтоомж, бодлого нь хувь хүний эрх чөлөө, үг хэлэх эрх чөлөөнд халдахгүй, арилжааны чанартай хохирол учруулахгүй байх ёстой.

### 1. Цахим гэмт хэрэг

#### 1.1 Цахим гэмт хэрэгтэй холбоотой үр дагавар

Залилан, хүүхдэд садар, самууныг сурталчлах, уруу татах, худал мэдээлэл түгээх зэрэг олон нийтийг хамарсан гэмт хэрэг нь хувь хүн, иргэд, нийгмийг бүхэлд нь хамардаг. Эдгээр гэмт хэргийн үр дагаврыг хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх нь чухал ач холбогдолтой юм.

#### 1.2 Залилан мэхлэх үйл ажиллагаа

Цахим сүлжээ нь хувийн мэдээлэл хулгайлах, санхүүгийн луйвар хийх зэрэгт өргөн ашиглагдаж байна. Кибер гэмт хэрэгтнүүд хэрэглэгчдийн итгэл, эмзэг байдлыг далимдуулан, санхүүгийн томоохон алдагдал, хохирол учруулдаг. Цахим луйврын нөлөө нь хувь хүний хохирогчдоос давж, бизнес эрхлэгчид, цахим гүйлгээнд итгэх олон нийтийн итгэл, эдийн засгийн тогтвортой байдалд нөлөөлдөг.

Олон нийтийн сүлжээнд гарч буй залилан, кибер гэмт хэрэг нь эдийн засагт ноцтой хохирол учруулж байна. Холбооны Худалдааны Комиссоос (FTC) гаргасан тайланд дурдсанаар зөвхөн АНУ-ын хэрэглэгчид луйврын улмаас 2022 онд 8.8 тэрбум долларын алдагдал хүлээсэн бөгөөд эдгээр луйврын ихээхэн хэсэг нь олон нийтийн платформоор дамжсан байна. Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр залилан мэхлэх үйлдлүүд олширч байгаа нь цахим худалдаа, дижитал эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлж байна. Тухайлбал, 2019 онд сошиал медиа луйврын түгээмэл хэлбэр болох "Нигерийн хунтайж" луйвар дэлхий даяар олон сая доллараар хохирогчдыг залилсан. Луйварчид Нигериас их хэмжээний мөнгө шилжүүлэхэд тусламж хүсч буй хувь хүн мэт дүр үзүүлж, хохирогчдод санхүүгийн хохирол учруулж, сэтгэл санааны дарамт учруулсан.<sup>1</sup>

<sup>1</sup> CNBC: <https://www.cnn.com/2019/04/18/nigerian-prince-scams-still-rake-in-over-700000-dollars-a-year.html>



### 1.3 Хүүхдэд садар, самууныг сурталчлах, уруу татах

Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл олширч байгаа нь хүүхдэд садар, самууныг сурталчлах, уруу татах, бэлгийн мөлжлөгийг дэлгэрүүлэхэд түлхэц болж, хүүхдийн аюулгүй байдалд ноцтой аюул учруулж байна. Цахим сүлжээгээр хүүхдүүдийн эмзэг байдлыг ашиглан тэднийг буруу зүйлд уруу татах, өдөөн хатгах нь ихэвчлэн урт хугацааны сэтгэл санааны хохирол учруулдаг. Түүнчлэн, хүүхдэд садар, самууныг сурталчлах, уруу татах нь тухайн улсын нэр хүндийг унагаж, яаралтай арга хэмжээ авахыг шаарддаг.

Тухайлбал, 2022 онд Facebook "хүүхдийн нүцгэн байдал, бэлгийн мөлжлөг" агуулсан 80 сая гаруй контентыг тэмдэглэж, устгасан. Үүнтэй төстэй хандлага олон нийтийн мэдээллийн хэрэгслийн бүх платформ дээр гарсаар байгаа бөгөөд олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан хүн худалдаалах гэмт хэрэг нэмэгдэж байна.<sup>2</sup> Эдгээр гэмт хэрэгт өртөж буй хүмүүсийг хамгаалах хууль, тогтоомж яаралтай батлах шаардлага тулгарч байна.

### 1.4 Худал мэдээлэл тараах

Олон нийтийн сүлжээгээр худал, ташаа мэдээлэл хурдан тархдаг. Хуурамч мэдээ, цуурхал, асар хурдтай тархаж байгаа нь олон нийтийг бухимдуулах, үймээн самуунд турхирах, байгууллагуудад итгэх итгэлийг эвдэх зэрэг сөрөг үр дагавар дагуулдаг.

Тухайлбал, Facebook-ийн хэрэглэгчдийн мэдээллийг улс төрийн сурталчилгаа хийх, хууран мэхлэх зорилгоор хууль бусаар цуглуулсан Cambridge Analytica-ийн дуулиан нь сонгуулийн үр дүнд нөлөөлж, олон нийтийн санаа бодлыг эргүүлж болох ноцтой асуудал бий болгосон<sup>3</sup>. Мэдээллийн бүрэн бүтэн байдлыг хангах, ардчилсан үйл явцыг хамгаалах хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх шаардлага энэ жишээнээс харж болно.

### 1.5 Сэтгэл зүй, сэтгэцийн эрүүл мэндэд үзүүлэх нөлөө

Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр хүн дээрэлхэх, дарамтлах, хор хөнөөлтэй контентыг түгээх зэрэг нь хувь хүний сэтгэл зүй, оюун санаанд ихээхэн нөлөөлдөг. Энэхүү байдалд хүүхэд, өсвөр насны залуучууд их өртөж байгаа нь сэтгэл гутралд автах, амиа хорлох явдлыг нэмэгдүүлж байна.

---

<sup>2</sup> Comparitech: <https://www.comparitech.com/blog/vpn-privacy/child-abuse-online-statistics/>



Тухайлбал, Канадын Аманда Тодд хэмээх өсвөр насны охин 2012 онд цахим дээрэлхэлтэд өртөж амиа хорлосон нь олон нийтийн сүлжээ сэтгэцийн эрүүл мэндэд ямар хор хөнөөлтэйг харуулж буй тул иргэдийн аюулгүй байдлыг хамгаалах хууль тогтоомж батлах шаардлагатай байна.

## **2. Олон нийтийн сүлжээ, түүний засаглалтай холбоотой Монгол Улсын одоогийн хууль тогтоомж**

### **2.1 Монгол Улсын хууль эрх зүйн орчин**

Монгол Улс олон нийтийн сүлжээ ашигласнаас үүдэн гарч буй сөрөг нөлөөллийг бууруулахын тулд хэд хэдэн хууль тогтоомжийг хэрэгжүүлсэн.

Энэ хэсэгт цахим гэмт хэрэг, хүүхдийн садар самуун, худал мэдээлэл зэрэг хууль тогтоомжийг онцолж, Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль эрх зүйн орчныг тоймлон харуулав. Мөн энэ хэсэгт 2023 оны эхээр УИХ-д өргөн мэдүүлсэн маргаантай, хориг тавьсан хууль болох “Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хууль”-ийг танилцуулах болно.

### **2.2. Монгол Улсын Эрүүгийн тухай хууль**

Монгол Улсын Эрүүгийн тухай хуульд бэлгийн гэмт хэрэг, цахим сүлжээний гэмт хэрэг, олон нийтийн сүлжээгээр тархаж буй худал мэдээлэлтэй холбоотой олон төрлийн заалтууд багтсан. Тус хуулиар насанд хүрээгүй хүүхдэд хүүхдэд садар, самуун/биеэ үнэлэлтийг сурталчлах, түгээх, гүтгэх, үзэн ядсан үг хэллэг, хувь хүн болон олон нийтийн хэв журамд сөргөөр нөлөөлж болзошгүй худал мэдээлэл тараах зэрэг асуудлыг шийдвэрлэдэг. Хортой контентын тархалттай тэмцэх, хариуцлагыг хангах асуудлыг тус хуулиар зохицуулдаг ч олон нийтийн мэдээллийн хэрэгслийн хүрээнд тусгайлан тодорхойлж өгөөгүй бөгөөд цахим үр дүнтэй засаглалыг хангах чиглэлээр нарийн заалт тусгаагүй байна.

### **2.3 Кибер аюулгүй байдлын тухай хууль**

Кибер аюулгүй байдлын тухай хууль (2021) нь Монгол Улсад мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах, кибер аюул заналхийлэлтэй тэмцэх үндсэн хууль болж байна. Энэ нь аюулгүй байдлын арга хэмжээг хэрэгжүүлэх, мэдээллийн чухал дэд бүтцийг хамгаалах чиглэлээр байгууллагуудад тавигдах шаардлагыг тогтоодог. Кибер аюулгүй байдлын тухай хууль нь залилан мэхлэх, компьютерийн системд зөвшөөрөлгүй нэвтрэх зэрэг цахим гэмт хэргийг шийдвэрлэх үндэс суурь болж өгдөг.

### **2.4 Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль**

Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль (2021) нь хувь хүний хувийн мэдээллийг хамгаалахад чиглэгдсэн. Хэдийгээр тус хууль нь олон нийтийн



мэдээллийн хэрэгсэлд хамаарахгүй ч дижитал платформтой харилцахдаа хэрэглэгчдийн хувийн нууц, хувийн мэдээллийг хамгаалахад нэн чухал юм. Олон нийтийн сүлжээний платформууд нь өгөгдөл хамгаалах дүрэм журмыг дагаж мөрдөх, хэрэглэгчийн хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, хуваалцахад зөвшөөрөл авах шаардлагатай.

## **2.5 Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хууль**

Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийг 2023 оны нэгдүгээр сард өргөн мэдүүлж, нэн яаралтай хэлэлцүүлэхээр баталсан ч олон нийтийн санаа бодлыг тусгаагүй гэх шалтгаанаар Ерөнхийлөгч хориг тавьсан. Монгол дахь Америкийн Худалдааны Танхим (АмЧам) нь Монгол Улсын Ерөнхийлөгч энэхүү маргаантай хуулийн төсөлд хориг тавихад хувь нэмрээ оруулан бодлогын нөлөөллийн томоохон кампанит ажлыг амжилттай хэрэгжүүлсэн.

Түүнчлэн 2023 оны 3-р сарын 13-ны өдөр АмЧам Монгол нь МҮХАҮТ, Европын худалдааны танхим, Их Британийн Худалдааны Танхим, Герман-Монголын хамтарсан худалдаа, аж үйлдвэрийн танхим зэрэг бизнесийн бусад танхимуудтай хамтран хоригийг хүлээн авахыг УИХ-ын гишүүдэд уриалсан хэвлэлийн мэдээлэл гаргасан билээ. Хуулийн төсөл боловсруулахдаа ил тод, хүртээмжтэй байдлыг хангаагүй, мөн хуулийн хор уршгийг авч хэлэлцээгүй гэх шалтгаанаар тул хоригийг УИХ хүлээж авсан.

Тус хууль нь үг хэлэх эрх чөлөөг халах гэсэн яарч боловсруулсан далд оролдлого, иргэд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэхээс урьдчилан сэргийлэх, төрөөс олон нийтийн мэдээллийн хэрэгсэлийг зохицуулах, хууль хяналтын байгууллагуудад нөлөөлөх, үг хэлэх эрх чөлөөг өөрсдөдөө ашигтай байдлаар хязгаарлах гэсэн оролдлого хэмээн ихээхэн шүүмжлэл дагуулсан.

## **3. Олон нийтийн сүлжээг зохицуулахад тулгарч буй бэрхшээлүүд**

### **3.1 Үг хэлэх эрх чөлөөг тэнцвэржүүлэх**

Олон нийтийн сүлжээг зохицуулах нь чухал болж байгаа ч үг хэлэх эрх чөлөөг ямар нэг байдлаар хязгаарлахгүй байх нь чухал юм. Ардчиллын зарчмыг баримтлах салшгүй нэг хэсэг нь хувь хүн өөрийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломжийг олгодог. Энэ нь засгийн газрын эрх мэдэл бүхий хүмүүст хариуцлага тооцох, ялангуяа засгийн газар сөрөг үзэл бодлыг хязгаарлах эсвэл чимээгүй болгох хүсэл эрмэлзэлтэй байгаа үед засгийн газрын хэт их нөлөөллөөс урьдчилан сэргийлэхэд чухал юм.

Олон нийтийн сүлжээ нь мэдээлэл олж авах, олон нийтийн яриа өрнүүлэх чухал талбар болсон нийгэмд хүмүүс олон талын үзэл бодолтой байж, итгэл



үнэмшлийнхээ дагуу шийдвэр гаргах замаар бие даасан байдлаа хадгалах чадвартай байх нь чухал юм.

### **3.2 Хэрэгжилт**

Хууль үр дүнтэй хэрэгжих нь Монгол Улсад тулгамдаж буй гол асуудал хэвээр байна. Хязгаарлагдмал нөөц, технологийн нарийн төвөгтэй байдал, нийгмийн сүлжээний гэмт хэргийн шинж чанар нь хууль сахиулах байгууллагуудад хүндрэл учруулж байна. Нэмж дурдахад, олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх, дижитал бичиг үсгийг сурталчлах, сошиал медиа платформуудтай хамтын ажиллагааг дэмжих нь чухал ач холбогдолтой.

Дараах хэсгүүдэд олон улсын жишгийг судалж, Монгол Улсад энэ чиглэлээр засаглал, хууль тогтоомжоо сайжруулах зөвлөмжийг өгөх болно.

## **4. Нийгмийн сүлжээний асуудалд хандах хууль тогтоох арга замууд**

### **4.1 Хууль тогтоох арга хэмжээ**

Дэлхийн улс орнууд, олон улсын хамтын нийгэмлэгүүд олон нийтийн сүлжээний гэмт хэрэгтэй холбоотой асуудлыг зохицуулах, хуульчлах шаардлагатайг хүлээн зөвшөөрч байна. Тодорхой хууль тогтоомжууд нь харилцан адилгүй боловч эдгээр сорилтыг үр дүнтэй шийдвэрлэхийн тулд хэд хэдэн нийтлэг хууль тогтоомжийн арга барил бий болсон. Энэ хэсэгт бусад улс орны хэрэгжүүлж буй зарим арга барилыг судалж, тэдний давуу болон сул талуудыг тодруулсан болно.

### **4.2 АНУ**

Харилцаа Холбооны Зохистой Байдлын тухай хууль, Хүүхдийн Цахим Мэдээллийн Нууцлалыг Хамгаалах тухай хууль (COPPA), Кибер Аюулгүй Байдлын Мэдээлэл Хуваалцах тухай хууль (CISA) зэрэг кибер аюулгүй байдлын тухай хууль тогтоомж байдаг. Эдгээр хууль нь хор уршиг дагуулах контентоос хамгаалах, хувийн нууцыг хамгаалах, кибер гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хүүхдийн цахим орчин дахь аюулгүй байдлыг дэмжих зорилготой.

Хууль бус үйл ажиллагааг АНУ-ын хууль тогтоомжид тодорхой заалтууд дээр үндэслэн тодорхойлсон байдаг. Тухайлбал, Харилцаа Холбооны Ёс Зүйн тухай хуулиар садар самуун буюу ёс суртахуунгүй цахим контентыг хориглодог бол COPPA нь 13-аас доош насны хүүхдийн цахим хувийн нууцлалыг хамгаалахад анхаардаг.

Холбооны Худалдааны Комисс (FTC) хувийн нууцлал, хэрэглэгчийн эрхийг хамгаалах асуудлыг (FTC), Харилцаа Холбооны Комисс (FCC) харилцаа холбоо, харин Хууль Зүйн Яам (DOJ) Кибер гэмт хэргийн мөрдөн байцаалттай холбоотой асуудлыг зохицуулдаг. Гэсэн хэдий ч АНУ олон нийтийн мэдээллийн хэрэгслээр





дамжуулсан ташаа мэдээллээс урьдчилан сэргийлэх, зохицуулах талаар тодорхой арга хэмжээ аваагүй байна. Мэдээллийн технологийн үйлчилгээ үзүүлдэг болон баримт нягталдаг байгууллагууд дээрх асуудлыг зохицуулахдаа үг хэлэх эрх чөлөөг хамгаалдаг.

### **4.3 Их Британи**

Их Британи нь цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хувийн мэдээллийг хамгаалах, хариуцлагатай цахим зан үйлийг төлөвшүүлэх зорилгоор Харилцаа Холбооны тухай хууль, Компьютерийг Зүй Бусаар Ашиглах тухай хууль, Мэдээлэл Хамгаалах тухай хууль, Цахим Аюулгүй Байдлын тухай хууль зэрэг цахим аюулгүй байдлын тухай хуулиуд баталсан.

Харилцаа Холбооны тухай хуульд хууль бус үйл ажиллагаа буюу доромжилсон, заналхийлсэн ёс суртахуунгүй контентыг хориглодог. Компьютерийг Зүй Бусаар Ашиглах тухай хуулиар компьютерийн системд зөвшөөрөлгүй нэвтэрсэн тохиолдлыг гэмт хэрэгт тооцдог бөгөөд Мэдээлэл Хамгаалах тухай хуульд хувийн мэдээлэлтэй ажиллах удирдамжийг тусгасан.

Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн платформ дээр хуваалцсан контентын төлөө хариуцлага хүлээх Онлайн Аюулгүй байдлын тухай цогц хуулийн дагуу олон нийтийн сүлжээний компаниуд хууль бус, сөрөг үр дагавар дагуулах контентыг нэн даруй устгах үүрэг хүлээдэг. Цахим платформ дээр хүүхдийн бэлгийн болон хөдөлмөрийн мөлжлөг, терроризм, кибер дээрэлхэлт зэрэг хэрэглэгчдийн аюулгүй байдалд хор учруулахгүй байх хуулийн заалт тусгасан.

Цахим аюулгүй байдлыг хангахын тулд засгийн газар болон цахим платформ хүчин чармайлт гарган хамтран ажиллах нь чухал юм.

### **4.4 Герман**

Герман улс цахим аюулгүй байдлыг хангах зорилгоор Сүлжээний Хэрэгжилтийн тухай хууль (NetzDG) болон Телемедиа хуулиудыг баталсан. Эдгээр хууль нь үзэн ядсан үг хэллэг, худал мэдээлэл, хууль бус цахим контенттой тэмцэхийн зэрэгцээ хэрэглэгчийн хувийн нууцыг хамгаалах зорилготой юм.

NetzDG нь олон нийтийн цахим платформыг зохицуулах асуудлыг тусгасан байдаг бөгөөд үзэн ядсан үг хэллэг, гүтгэлэг зэрэг хууль бус контентыг нэн даруй (24 цагийн дотор) устгахыг шаарддаг. Телемедиа хуульд мэдээллийн технологийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудад хувийн нууцыг хамгаалах, мэдээллийн аюулгүй байдлыг хангах тухай удирдамжийг тусгасан.



#### 4.5 Сингапур

Цахим Орчинд Худал Хуурмаг, Залилан Мэхлэхээс Хамгаалах тухай хууль (POFMA) нь худал мэдээлэл, ташаа мэдээлэл тархахтай тэмцэх зорилготой юм. Уг хуулиар засгийн газрын гишүүдэд цахим платформд залруулга хийх, татан буулгах шийдвэр гаргах эрхийг олгодог. Энэхүү хууль тогтоомж нь нийтийн эрх ашгийг хамгаалах, худал хуурмаг мэдээлэл түгээхээс урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журмыг сахихад чиглэгддэг.

Энэ нь цахим орчинд худал мэдээлэл хурдацтай тархаж буйг шийдвэрлэх механизм болж байгаа ч мэдээлэл, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд төрийн хяналт тавихтай холбоотой олон асуудал гарч ирж байна. Сингапурын засгийн газар дотоод хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон гадаад эх сурвалжид нэвтрэхэд хяналт тавьдаг.

#### Европын Холбоо

Европын холбоо Европ дахь "Цахим зах зээл"-ийг илүү ил тод, аюулгүй, хариуцлагатай болгохын тулд Цахим Зах Зээлийн тухай хууль болон Цахим Үйлчилгээний тухай хуулийг тус тус баталсан. Хуулийн өөрчлөлтөд зуучлалын үйлчилгээ, интернет үйлчилгээ (hosting service), томоохон цахим платформтой харилцах харилцааг тусгасан.

Бизнес эрхлэгч, хэрэглэгчдийг томоохон онлайн платформуудын шударга бус үйлдлээс хамгаалах, цахим зах зээл дэх тэгш өрсөлдөөнийг бий болгох, цахимаар зуучлах болон интернет үйлчилгээ үзүүлэхэд хариуцлага, ил тод байдлыг хангах, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, хэрэглэгчийн үндсэн эрхийг хамгаалах чиглэлээр хуулийн өөрчлөлтийг нэмсэн.

#### 4.7 Олон нийтийн сүлжээн дэх гэмт хэрэгтэй тэмцэх дэлхий нийтийн хүчин чармайлт

Олон нийтийн сүлжээн дэх гэмт хэрэгтэй тэмцэх, улс орнуудын хамтын ажиллагааг дэмжих зорилгоор олон санаачилга гаргасан. Ийм санаачилгын нэг бол хүүхдийн цахим хүчирхийллийн эсрэг WePROTECT дэлхийн холбоо юм. Тус холбоо нь засгийн газар, хууль сахиулах байгууллагууд, технологийн компаниудыг олон нийтийн хэвлэл мэдээллийн платформ дээр хүүхдийн хүчирхийллийн материалыг илрүүлэх, мэдээлэх, устгах ажлыг сайжруулах зорилгоор татан оролцуулдаг. Олон талт хамтын ажиллагаа нь нийгмийн сүлжээний гэмт хэргийг үр дүнтэй шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой юм.

#### Интернетийн Ирээдүйн тухай тунхаглал

2022 оны 4-р сарын 28-нд АНУ-ын Ерөнхийлөгч Байден улс үндэстний технологи ашиглах хэм хэмжээг тогтоодог дэлхийн шинэ түншлэл болох Интернетийн



ирээдүйн тухай тунхаглалыг зарлав. Энэхүү мэдэгдэлд Европын Комисс, Их Британи гэх мэт 61 улс гарын үсэг зурсан бөгөөд ардчилсан улс орнууд интернеттэй харьцах талаар ес зүйн дүрмийг тусгасан.

Тус тунхаглалын алсын хараа нь өргөн хүрээтэй бөгөөд бүх нийтээр интернетийн хүртээмжийг дэмжих, хүний эрхийг хамгаалах, эдийн засгийн шударга өрсөлдөөнийг хангах, найдвартай цахим дэд бүтцийг бий болгох, олон ургальч үзэл, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг дэмжих, интернетийн засаглалд олон талт хандлагыг баталгаажуулах зорилготой юм.

Тунхаглалын зарчмууд:

- Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах;
- Мэдээллийн чөлөөт урсгалыг бий болгох дэлхийн интернетийг дэмжих;
- Цахим эдийн засгийн үр шимийг хүртэхийн тулд хүртээмжтэй, боломжийн үнэтэй холболтыг сайжруулах;
- Хувийн нууцыг хамгаалах замаар дэлхийн цахим экосистемд итгэх итгэлийг дэмжих;
- Бүх нийтийн ашиг тусын тулд интернетийг ажиллуулж байгаа засаглалын олон талт хандлагыг хамгаалж, бэхжүүлэх.

Интернэт нь дэлхийн хэмжээнд хүртээмжтэй байхаас гадна олон талт арга барилаар зохицуулагддаг нэгдсэн, төвлөрсөн бус сүлжээ байх ёстой. Харин засгийн газар болон холбогдох эрх бүхий байгууллагууд эрдэмтэн судлаачид, иргэний нийгэм, хувийн хэвшил, техникийн нийгэмлэгтэй хамтран ажилладаг байвал зохистой.

Интернетэд тулгуурласан дижитал технологиуд нь нээлттэй, чөлөөтэй, дэлхий даяар харилцан ажиллах боломжтой, найдвартай, аюулгүй байх ёстой. Цахим технологийг найдвартай, чөлөөт, шударга өрсөлдөөнийг бий болгох замаар үйлдвэрлэх, ашиглах ёстой. Хэрэглэгчдийн хооронд шударга бусаар ялгаварлан гадуурхахаас зайлсхийх, хувь хүний хувьд үр дүнтэй сонголтыг баталгаажуулах; шударга өрсөлдөөнийг дэмжих, инновацийг дэмжих; хүний эрхийг дэмжих, хамгаалах болон доор дурдсан зарчмыг хангасан нийгмийг бүрдүүлэх. Үүнд:

- Хүний эрх, эрх чөлөө, хүн бүрийн сайн сайхан байдлыг хамгаалж, сурталчлах;
- Хаана байрлаж байгаагаас үл хамааран бүгд боломжийн үнэтэй, интернетэд нэвтрэх, холбогдох боломжтой байх.
- Хувь хүн, бизнес эрхлэгчид өөрсдийн ашиглаж буй цахим технологийн аюулгүй байдал болон тэдний хувийн нууцлалыг хамгаалж чадна гэдэгт итгэлтэй байх,



- Бизнесүүд шударга, өрсөлдөх чадвартай экосистемд шинийг санаачилах, өрсөлдөх;
- Дэд бүтэц аюулгүй, харилцан ажиллах боломжтой, найдвартай, тогтвортой байхаар бүтээгдсэн байх;
- Технологийг олон ургальч үзэл ба үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, тогтвортой байдал, эдийн засгийн хүртээмжтэй өсөлтийг дэмжих, дэлхийн уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэхэд ашигладаг байх.

#### **4.8 Харьцуулсан шинжилгээ**

Олон улс орон иргэдээ хамгаалах хууль тогтоомжийг батлахдаа олон нийтийн мэдээллийн хэрэгслийг зохицуулах асуудалд чухал анхаарал хандуулдаг. Гэхдээ эдгээр хуулийг хэр зэрэг авч хэрэгжүүлсэн нь улс орон бүрт харилцан адилгүй байна. Үүнд хүүхдийг бэлгийн болон хөдөлмөрийн мөлжлөгөөс хамгаалах, зохисгүй контент мэдээлэлд хандахаас сэргийлэх, үзэн ядсан үг хэллэгээс хамгаалах, хүчирхийлэл, террорист үйлдлийг сурталчилахаас урьдчилан сэргийлэх зэрэг хуулиуд багтдаг. Улс орнууд олон нийтийн сүлжээн дэх ташаа мэдээлэлд хариу үйлдэл үзүүлж байгаагаараа ялгаатай.

Илүү ардчилсан орнууд платформ дээрх ташаа мэдээллийг зохицуулахыг зөвшөөрсөн бол Сингапур зэрэг улсад олон нийтийн мэдээллийн хэрэгслээр тодорхой мэдээллийг хаах эрх мэдлийг засгийн газарт олгосон.

#### **5. Интернетийн үр дүнтэй засаглалын үндсэн зарчмууд**

Олон нийтийн мэдээллийн сүлжээний гэмт хэрэгтэй холбоотой асуудлыг үр дүнтэй зохицуулж, хуульчлахын тулд үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хангах, цахим гэмт хэргийн сөрөг үр дагавраас хамгаалах тэнцвэрт байдлыг хангах нь чухал юм.

Иймд дээрх асуудлыг шийдвэрлэх тогтолцоог бүрдүүлэх, интернет болон олон нийтийн мэдээллийн хэрэгслийг зохицуулахын тулд дээр дурдсан олон улсын шилдэг туршлагаудад үндэслэн АмЧам Монгол Улсын Их Хурал, Засгийн газарт дараах үндсэн зарчмуудыг баримтлахыг зөвлөж байна. Үүнд:

1. Монгол Улс интернетийн үр дүнтэй засаглалыг бий болгох дэлхийн энэхүү хүчин чармайлтад нэгдэж, Интернетийн ирээдүйн тунхаглалд гарын үсэг зурах,
2. Төр сургууль, номын санг хамгаалахаас бусад тохиолдолд хууль ёсны агуулгатай мэдээ мэдээлэл, контентийг хааж болохгүй. Тэд улс төрийн шалтгаанаар болон ардчиллын зарчимд харшлах бусад зорилгоор интернет, цахим сүлжээнд төрийн хяналт тавихгүй байх,



3. Засгийн газар болон холбогдох эрх бүхий байгууллагаас хувийн мэдээлэлд хандах эрх нь үндэсний хууль тогтоомж, хүний эрхийн олон улсын хууль тогтоомжид нийцсэн байх ёстой. Хувь хүний нууц, цахим харилцааны нууцлал, хувийн мэдээлэл, эцсийн хэрэглэгчийн цахим төхөөрөмжийн мэдээлэл хамгаалагдсан байх ёстой.

4. Засгийн газар иргэдээ үзэн ядсан үг хэллэг, ташаа мэдээлэл, хүүхдийн хүчирхийлэл зэрэг цахим сүлжээний хор хөнөөлөөс хамгаалахдаа үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, хувийн нууцыг хамгаалах зэрэг хүний үндсэн эрхийг хүндэтгэх.

Энэ нь хууль бус эсвэл хортой контентыг зохицуулахын тулд цахим платформ ажиллуулж буй иргэд, байгууллагад практик бус эсвэл хэт их үүрэг хариуцлага хүлээлгэхгүй байх.

5. Интернэтийг сонгуулийн систем, сонгууль, улс төрийн үйл явцыг бусниулахын тулд ашиглахгүй байх.

6. Хүний эрхийн үндсэн зарчмуудыг зөрчиж, хууль бусаар тандалт хийх, хэлмэгдүүлэх, баривчлах агуулгатай интернет эсвэл алгоритмын хэрэгсэл, арга техникийг хориглох.

## **Дүгнэлт**

Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл хурдацтай хөгжиж байгаа нь Монголын нийгэмд боломж, сорилтуудыг бий болгосон. Цахим платформууд нь харилцаа холбоо үүсгэх, мэдээлэл олж авах боломжийг бүрдүүлэхийн зэрэгцээ залилан, хүүхдийн садар самуун, цахим дээрэлхэлт, худал мэдээлэл түгээх зэрэг цахим гэмт хэрэг гарахад хүргэж байна.

Цахим гэмт хэрэгтэй холбоотой асуудлыг үр дүнтэй зохицуулж, хуульчлахын тулд гарч болох сөрөг үр дагавараас хамгаалах нөхцлийг бүрдүүлэх, мөн үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хамгаалах, нэн ялангуяа улс төрийн холбогдолтой яриа хэлэлцүүлэг өрнүүлэх, дургүйцлээ илэрхийлэх эрх үүнд хамаарна.

Олон улсын шилдэг туршлагаас үндэслэн Монгол Улс сошиал медиа гэмт хэргийг зохицуулахад олон талт хандлагыг баримтлахыг зөвлөж байна. Нийгмийн сүлжээний гэмт хэрэгтэй холбоотой асуудлыг үр дүнтэй зохицуулж, хуульчлахын тулд хувь хүн болон нийгмийг хамгаалах хэрэгцээг үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хадгалахтай тэнцвэржүүлсэн цогц арга барил шаардлагатай. Энэхүү бодлогын баримт бичигт тусгагдсан зөвлөмжийг хэрэгжүүлснээр Монгол Улс сошиал сүлжээний гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэж, иргэдээ хамгаалж, цахим орчинд аюулгүй байдлыг бий болгож чадна. Эдгээр зорилтыг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагууд, хууль сахиулах байгууллагууд,



олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, иргэний нийгмийн байгууллагууд, олон нийтийн хамтын ажиллагаа чухал үүрэг гүйцэтгэнэ. Динамик дижитал ландшафт дахь хөгжиж буй сорилтуудтай хөл нийлүүлэн алхах стратегийг байнга үнэлж, өөрчлөх нь маш чухал юм.

Эдгээр зөвлөмжийг хүлээн авснаар Монгол Улс нийгмийн сүлжээний гэмт хэрэгтэй тэмцэх, иргэдээ хамгаалах, дижитал эрин үед ардчиллын үнэт зүйлс, тэр дундаа үг хэлэх эрх чөлөөг дээдлэх чиглэлээр манлайлан ажиллах боломжтой.



### Тэмдэглэл

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

---

